

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын захиалгаар хийсэн НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“МОНГОЛ ХАТДЫН ӨРГӨӨ” ЦОГЦОЛБОРЫН АШИГЛАЛТЫН ӨМНӨХ ЗАХИРГААНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХӨРӨНГИЙГ ҮНЭЛЖ БҮРТГЭЭГҮЙ БАЙНА.

Аудитын нэр: **Монгол Хатдын өргөө цогцолборын ашиглалтын өмнөх захиргааны 2014-2017 оны үйл ажиллагаа**
Аудитын код: ХЭА-/2018/01/-НА



**Өндөрхаан хот
2018 он**

УУЛГА	Товчилсон үгийн жагсаалт	2
	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй	3-4
	Ерөнхий мэдээлэл	4
Аудитыг гүйцэтгэсэн:	Бүлэг 1:	
Хэнтий аймаг дахь Эрх зүйн Аудитын газар	Хэнтий аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2013 оны 6 сарын 13-ны өдрийн 67 дугаар тогтоолоор "Монгол хатдын өргөө" цогцолборын ашиглалтын өмнөх захиргааг байгуулсан нь Барилгын тухай хуулийн 48.3 "Гэрчилгээ олгогдоогүй, дуусаагүй барилга байгууламжид үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно." гэсэн заалтыг зөрчсөн байна.	5-7
Тэргүүлэх аудитор Ч.Эрдэнэбаатар	<ul style="list-style-type: none"> • "Монгол хатдын өргөө" цогцолборын ашиглалтын өмнөх захиргааг байгуулсан нь хууль зөрчсөн байна. 	5
Аудитын менежер Д.Оюунтуяа	<ul style="list-style-type: none"> • Монгол хатдын өргөө" цогцолборын ашиглалтын өмнөх захиргааны хуулийн этгээдийн хариуцлагын хэлбэрт нийцүүлэн ажиллах журмыг боловсруулж, батлаагүй байна. 	6
Туслах аудитор Н.Туяа	<ul style="list-style-type: none"> • Баригдсан барилга байгууламжийг 5 жил үйл ажиллагаа явуулснаас хойш "барилга байгууламжийг ашиглалтанд оруулах улсын комисс" хүлээн авсан байна. 	6-7
Аудитор Ж.Болор-Эрдэнэ		
2018 оны 06 дугаар сарын 20	Бүлэг 2:	
	"Монгол хатдын өргөө" цогцолборын ашиглалтын өмнөх захиргааны ажиллах журам нь хуулийн этгээдийн хэлбэр ААТҮГ-т нийцээгүй, байгууллагын үйл ажиллагаа хангалтгүй байна.	7-9
Аудитын тайлан, Түгнэлттэй холбоотой хуудал байвал 562147 дугаарын утас, 562112 дугаарын факсаар харилцана уу	<ul style="list-style-type: none"> • Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн баталсан журмын хэрэгжилт хангалтгүй байна. • Үйл ажиллагааны зорилго зорилтыг хангалтгүй хэрэгжүүлж байна. • Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй байна. 	7 7-8 8-9
ХАЯГ:	Бүлэг 3:	
Хэнтий аймаг Эрх зүйн сум Хэнтий аймгийн ЗДТГ-ын байр Тусгай тоот	Орон нутгийн өмчийн газар нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон барилга байгууламжийг эзэмшигч байгууллагад нь шилжүүлж, санхүүгийн тайлан балансад бүртгүүлэх ажлыг зохион байгуулаагүй байна.	9-
	<ul style="list-style-type: none"> ▪ Хөрөнгө оруулалтаар бий болсон өмч хөрөнгийг үнэлж санхүүгийн тайлан, нягтлан бодох бүртгэлд тусгаагүй байна. ▪ Зарим хөрөнгийг зориулалтын дагуу ашиглах, хөрөнгөд засвар үйлчилгээг хийх шаардлагатай байна. 	9-10 10-11
	Дүгнэлт.....	12
	Зөвлөмж.....	12-13
	Холбогдох байгууллагын санал:	14

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ, СТАНДАРТЫН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ

1. Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

Аудитыг Монгол Улсын Ерөнхий аудиторын 2018 оны 01 сарын 05 өдрийн А/05 тушаалыг үндэслэн, Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газрын 2018 онд хийх аудитын төлөвлөгөөний дагуу “Төрийн аудитын тухай” хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1 дэх бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

2. Аудитын зорилт:

“Монгол хатдын өргөө” цогцолборын ашиглалтын өмнөх захиргааны 2014-2017 оны үйл ажиллагааг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулсан эсэхэд аудит хийж, гарсан зөрчлийг арилгах, цаашид сайжруулах, санал, зөвлөмж боловсруулан холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх, аудитын дүнг аймгийн ИТХ-д танилцуулахад аудитын зорилт чиглэгдсэн.

Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудит хийв. Үүнд:

- Үйл ажиллагааг хууль эрх зүйд нийцүүлэн зохион байгуулсан эсэх;
- Ашиглалтын өмнөх захиргаа батлагдсан журмын дагуу үйл ажиллагаа явуулсан эсэх
- Хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт зүй зохистой эсэх

3. Аудитын хамарсан хүрээ:

Аудитад аймгийн ИТХ, СТСХ, ГХБХБГ, ОНӨГ, Баян-Адрага сумын ЗДТГ -ыг хамруулж, “Монгол хатдын өргөө” цогцолборын ашиглалтын өмнөх захиргааг байгуулахтай холбоотой аймгийн ИТХ-ын тогтоол шийдвэр, баталсан журам, 2014-2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан, мэдээ, санхүүгийн баримт материалыг хамруулан гүйцэтгэлээ.

4. Аудитын арга зүй, стандарт мөрдөлт:

Аудитыг нийцлийн аудитын удирдамж АДБОУС 100-400, 4200 -г ашиглан, Нийцлийн аудитын түр журмыг баримтлан гүйцэтгэж, “Монгол хатдын өргөө” цогцолборын ашиглалтын өмнөх захиргааны холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглан, аудитын горимын дагуу нотлох зүйл цуглуулж, дүн шинжилгээ хийн аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

5. Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд:

Аудитын зорилттой холбоотой дараах хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав. Үүнд:

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Барилгын тухай хууль

- Төсвийн тухай хууль,
- МУ-ын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль
- Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2013 оны 06 дугаар сарын 13-ны 67 дугаар тогтоолоор баталсан журам
- Холбогдох бусад хууль тогтоомж, заавар журам

6. Аудит хийсэн багийн бүрэлдэхүүн:

Аудитыг Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Ч.Эрдэнэбаатар удирдан зохион байгуулж, аудитын менежер Д.Оюунтуяа аудитын үе шатны ажлын чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Н.Туяа, аудитор Ж.Болор-Эрдэнэ нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэлээ.

7. Хүндрэл бэрхшээл

Аудитад 224.0 сая төгрөгийн төсөв бүхий "Дуурлиг нарс-Хүннү, Монгол ээж музейн барилга, номын сан, усан оргилуур" төсөл арга хэмжээний баримт материал хангалтгүй, гүйцэтгэл тодорхойгүй тул хамруулаагүй болно. Мөн аудитыг гүйцэтгэхэд өмнөх онуудад ажиллаж байсан захирал өөрчлөгдсөн тул мэдээлэл авахад хүндрэлтэй байв.

8. Аудитын хугацаа.

Аудитын төлөвлөлтийг 2018 оны 05-р сарын 07-нд эхэлж, тайланг 2018 оны 06-р сарын 20-нд дуусгав.

9. Ерөнхий мэдээлэл

Хэнтий аймгийн Баян-Адрага сумын нутагт байгуулсан "Монгол хатдын өргөө" цогцолбор төсөл арга хэмжээ нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2010 онд 334.0 сая төгрөг, 2011 онд 117.0 сая төгрөг, нийт 451.0 сая төгрөгийн хөрөнгөөр санхүүжигдэн, "ӨҮ ТИ ЮУ" ХХК гүйцэтгэсэн байна. Энэхүү төслийн зорилго нь **"Монголын сүүлчийн хаан VIII Жавзандамба хутагтын хатан Цэндийн Дондогдулам хатны болон монголын түүхт хатдын Монголын төрд байгуулсан гавъяа, хатан хүний ухаалаг зан чанар, Монголын түүх соёл иргэншлийг тусгасан орчин үеийн архитектурын өвөрмөц шийдэл бүхий барилга байгууламжийн хослол бүхий олон улсын стандартад нийцсэн цогц үйлчилгээг хүргэх цогцолбор барьж байгуулахад төслийн гол зорилго оршино"** гэж тодорхойлсон байна.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2013 оны 6 сарын 13-ны 67 тогтоолоор "Монгол хатдын өргөө цогцолборын ашиглалтын өмнөх захиргаа"-г байгуулан, ажиллах журмыг хавсралтаар баталсан байна. Байгууллагын бүтэц орон тоог удирдах-дарга 1, үйлчлэх - манаач 1, гэрээт -тайлбарлагч 1, нийт 3 орон тоогоор зохион байгуулж үйл ажиллагаагаа явуулж байна.

10. Аудитын дүн

НЭГ. Хэнтий аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2013 оны 6 сарын 13-ны өдрийн 67 дугаар тогтоолоор "Монгол хатдын өргөө" цогцолборын ашиглалтын өмнөх захиргааг байгуулсан нь Барилгын тухай хуулийн 48.3 "Гэрчилгээ олгогдоогүй, дуусаагүй барилга байгууламжид үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно." гэсэн заалтыг зөрчсөн байна.

1.1. Монгол хатдын өргөө цогцолборын ашиглалтын өмнөх захиргааг байгуулсан нь хууль зөрчсөн байна.

✓ 1.1.1. "Монгол хатдын өргөө" цогцолборын ашиглалтын өмнөх захиргааг тус объектын өмч, хөрөнгийг хадгалах, хамгаалах зорилгоор Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3 ж¹, 25 дугаар зүйлийн 25.1² дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2.4³ заалтуудыг тус тус үндэслэн Хэнтий аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2013 оны 6 дугаар сарын 13-ны өдрийн 67 дугаар тогтоолоор хуулийн этгээд байгуулах тухай шийдвэрлэсэн байна.

✓ 1.1.2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2010-2012 онд баригдсан "Монгол хатдын өргөө" цогцолборын барилгыг барилга байгууламжийг ашиглалтанд оруулах улсын комисс хүлээн аваагүй байхад аймгийн ИТХ-ын 2013 оны 06 сарын 13-ны 67 дугаар тогтоолоор "Монгол хатдын өргөө цогцолборын ашиглалтын өмнөх захиргаа" ОНӨААТҮГ байгуулан үйл ажиллагаа явуулсан нь Барилгын тухай хуулийн 48.3⁴ дэх заалтыг зөрчсөн байна.

Тухайн үед гүйцэтгэгч "Өү-Ти-Юу" ХХК нь холбогдох бичиг баримтыг бүрдүүлж ирүүлээгүйгээс шалтгаалан хөрөнгө оруулалтаар баригдсан цогцолборын барилга, байгууламжийг улсын комисс хүлээн аваагүй байна.

Гүйцэтгэгч компани төсөл арга хэмжээг бүрэн дуусгаж улсын комисст хүлээлгэн өгөөгүй байхад аймгийн ИТХ-аас "Монгол хатдын өргөө" цогцолборын ашиглалтын өмнөх захиргааг байгуулан үйл ажиллагаа явуулсан нь холбогдох хууль тогтоомжийг зөрчих, төслийн зорилго зорилтыг хангалтгүй хэрэгжүүлэхэд нөлөөлсөн байна.

✓ 1.1.3. Уг тогтоолын дагуу хуулийн этгээдийн бүртгэлд "Монгол хатдын өргөө" цогцолборын ашиглалтын өмнөх захиргаа нь "Орон нутгийн өмчит ААТҮГ" бөгөөд үндсэн үйл ажиллагааны чиглэлийг "Монгол хатдын өргөө" цогцолборын түүхэн соёлын үнэт өвийг хадгалах, хамгаалах, таниулан сурталчлах, судалгааны ажил зохион байгуулах, музейн үйлчилгээ үзүүлэх" гэж тодорхойлон, 2013 оны 12 дугаар сарын 04-нд бүртгэгдэн улсын бүртгэлийн гэрчилгээ авсан байна.

¹ "орон нутгийн өмчит хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргах, дүрмийг батлах."

² "Хурал хэлэлцсэн асуудлаар тогтоол гаргах бөгөөд түүнийг тухайн Хурлын хуралдаанд оролцсон төлөөлөгчдийн болон баг, хорооны Хурлын хуралдаанд оролцсон иргэдийн олонхийн саналаар тус тус батална."

³ "орон нутгийн өмчийн хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргаж, гүйцэтгэлд нь хяналт тавих."

⁴ "Гэрчилгээ олгогдоогүй, дуусаагүй барилга байгууламжид үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно."

1.2. “Монгол хатдын өргөө” цогцолборын ашиглалтын өмнөх захиргааны хуулийн этгээдийн хариуцлагын хэлбэрт нийцүүлэн ажиллах журмыг боловсруулж, батлаагүй байна.

1.2.1. Хэнтий аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2013 оны 6 сарын 13-ны өдрийн 67 дугаар тогтоолын хавсралтаар “Монгол хатдын өргөө” цогцолборын ашиглалтын өмнөх захиргааны ажиллах журмыг баталсан байна.

1.2.2. Улсын бүртгэлийн гэрчилгээний ААТҮГ гэсэн хуулийн этгээдийн хариуцлагын хэлбэрт уг журмын 1.3-д “Орон нутгийн өмчит Монгол хатдын өргөө цогцолборын ашиглалтын өмнөх захиргаа нь Орон нутгийн өмчийн тухай хуулийн дагуу зохион байгуулагдаж, бие даасан тайлан тэнцэлтэй, банкинд харилцах данстай, өөрийн нэрийн өмнөөс эрх эдлэн, үүрэг хүлээх төсөвт байгууллагын хэлбэрээр ажиллана” гэж заасан нь нийцэхгүй байна.

1.2.3. Мөн журамд “Орон нутгийн өмчит Монгол хатдын өргөө цогцолборын ашиглалтын өмнөх захиргаа нь төсөвт байгууллагын хэлбэрээр ажиллана” гэж заасан бөгөөд уг байгууллага нь төрийн сангийн харилцах тусгай дансгүй, сумын ЗДТГ-ын төсвийн хуваарьт “Төрийн өмнөөс гүйцэтгэх ажил үйлчилгээ” зардлаар дамжуулан санхүүгийн дэмжлэг авч байгаа нь Төсвийн тухай хуулийн 4.1.34⁵ дэх заалттай нийцэхгүй байна.

Хуулийн этгээдийн хариуцлагын хэлбэрт батлагдсан журам нь нийцээгүй, тодорхойгүй нөхцөл байдал үүсгэсэн байна.

1.3. Баригдсан барилга байгууламжийг 5 жил үйл ажиллагаа явуулснаас хойш “барилга байгууламжийг ашиглалтанд оруулах улсын комисс” хүлээн авсан байна.

1.3.1. Хэнтий аймгийн Баян-Адрага сумын нутагт “Монгол хатдын өргөө” цогцолбор төсөл арга хэмжээнд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2010 онд 335.0 сая төгрөг, 2011 онд 110.0 сая төгрөг, нийт 445.0 сая төгрөг батлагдсан байна.

1.3.2. Аймгийн СТСХ-ээс “Монгол хатдын өргөө” цогцолборын барилгад 2010 онд 334.0 сая төгрөг, 2011 онд 117.0 сая төгрөг, нийт 451.0 сая төгрөгөөр санхүүжүүлсэн байна.

1.3.3. Барилгын тухай хуулийн Захиалагчийн чиг үүрэг 37.1.6.⁶ дахь заалтыг хэрэгжүүлээгүйгээс Баян-Адрага суманд 2010-2012 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар “Өү-Ти-Юу” ХХК барьж гүйцэтгэсэн “Монгол хатдын өргөө” цогцолборын барилга, байгууламжийг захиалагч болон гүйцэтгэгч компанийн ажлын хариуцлагагүй үйл ажиллагаанаас шалтгаалан 2013-2017 оны 6 сар

⁵ “төсвийн байгууллага” гэж батлагдсан төсвийн дагуу төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хэрэгжүүлдэг, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 7.1.3-т заасны дагуу санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад бүртгүүлсэн төрийн болон орон нутгийн өмчит, ашгийн төлөө бус хуулийн этгээдийг” хэлнэ.”

⁶ энэ хуулийн 48.1-д заасны дагуу барилга байгууламжийг ашиглалтад оруулах ажлыг зохион байгуулах;

хүртэл барилга байгууламжийг ашиглалтанд оруулах улсын комисст хүлээлгэн өгөөгүй байна.

Энэ нь холбогдох хууль тогтоомжийг зөрчиж, улмаар хөрөнгө оруулалтын төслийн үр өгөөжийг бууруулсан байна.

1.3.4. "Монгол хатдын өргөө" цогцолборыг "Барилга байгууламжийг ашиглалтанд оруулах улсын комисс"-ын 2017 оны 6 дугаар сарын 02-ны БУА-03/2017 дугаар актаар хүлээн авсан байна.

ХОЁР. "Монгол хатдын өргөө" цогцолборын ашиглалтын өмнөх захиргааны ажиллах журам нь хуулийн этгээдийн хэлбэр ААТҮГ-т нийцээгүй, байгууллагын үйл ажиллагаа хангалтгүй байна.

2.1. Аймгийн ИТХ-аас баталсан журмын хэрэгжилт хангалтгүй байна.

2.1.1. Баян-Адрага суман дахь "Монгол хатдын өргөө" цогцолборын ашиглалтын өмнөх захиргааны даргаар Хэнтий аймгийн Засаг даргын 2013 оны 08 дугаар сарын 01-ний А/359 дүгээр захирамжаар М.Мөнхбат, 2017 оны 06 дугаар сарын 30-ний Б/95 дугаар захирамжаар Х.Ганболд нар тус тус томилогдсон байна.

2.1.2. 2013- 2017 оны 6 сарыг дуусталх хугацаанд хийсэн ажил, үйл ажиллагааны талаарх төлөвлөгөө, тайлан мэдээ, танилцуулгыг аудитад бүрэн хамруулаагүй болно.

Захирлаар ажиллаж байсан М.Мөнхбат нь 2013 оноос 2016 оны 6 сарыг дуусталх хугацаанд ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтыг боловсруулан гаргаж, ажиллагсадтай хөдөлмөрийн гэрээ байгуулж, мөн 2013-2016 онуудад хийх үйл ажиллагааны төлөвлөгөөг гаргасан, 2013, 2016 онд үйл ажиллагааныхаа тайланг аймгийн ИТХ-д, тухайн жилийн ажлын тайлан болон дараа оны ажлын чиглэл, төсвийн төслийг боловсруулан аймгийн Засаг даргад тус тус хүргүүлсэн байна.

Мөн холбогдох бичиг баримттай танилцахад гадаад, дотоодын олон нийтийн байгууллагатай харилцаа холбоог тогтоож ажилласан байна.

Харин 2017 оны 6 сараас хойш шинээр томилогдсон захирал Х.Ганболд нь аймгийн Засаг даргатай гэрээ байгуулаагүй, үйл ажиллагааны төлөвлөгөөг хийж батлуулаагүй, хийсэн ажлын тайлан гаргаагүй байна.

Дээрхи байдлаас үзэхэд журмын 3.6⁷ дахь, 6.4⁸ дахь заалтууд бүрэн хэрэгжээгүй байна.

2.2. Үйл ажиллагааны зорилго зорилтыг хангалтгүй хэрэгжүүлж байна.

⁷ "Улс эх орны нийгэм эдийн засгийн хөгжил, спор, аялал жуулчлал, соёл, урлаг, нийтийн биеийн тамирын үйл ажиллагааг үйл ажиллагааны төлөвлөгөөндөө тусгаж ажиллах"

⁸ " Монгол хатадын өргөө ЦАӨЗ-ны захирал нь үйл ажиллагааны үр дүнгийн биелэлтээ жилд нэгээс доошгүй удаа аймгийн ИТХ-д тайлагнан дүгнүүлж байна."

2.2.1. Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн баталсан журмаар Монгол Улсын Их Хатдыг алдаршуулах, таниулах, мөнхжүүлэх, хүндэтгэх зорилгоор бүтээн байгуулсан Монгол хатдын өргөө цогцолбор нь Монголын ард түмний түүхэн хөгжлийн цаг үеийн

Явуулах үйл ажиллагааны төрөл

1. Аялал жуулчлал,
2. сургалт сурталчилгааг явуулж,
3. бэлэг дурсгалын үйлдвэрлэл,
4. худалгаа үйлчилгээ,
5. мод тарих, зүлэг, ногоо суулгах,
6. зам талбайн тохижилт, сэргээн засварлах үйлчилгээ,
7. музейн үйлчилгээ,
8. судалгаа шинжилгээний ажил,
9. фото студи ажиллуулах,
10. түрээсийн үйлчилгээ

мэдээллийн санг өөртөө агуулсан соёлын үнэт өв, түүхэн дурсгалт газар бөгөөд иргэдэд түүхийг таниулах, сурталчлах, аялал жуулчлалын зөв орчинг бүрдүүлэх, хөдөө орон нутгийг хөгжүүлэх, уламжлалт зан заншил, ёс суртахууныг зөв төлөвшүүлэхэд удирдлага зохион байгуулалт, үйл ажиллагааны зөв менежмент хэрэгжүүлэн дараах үйл ажиллагааг явуулахаар тодорхойлсон байна.

Үүнээс: Зөвхөн аялал жуулчлал, сургалт сурталчилгааны үйл ажиллагааг явуулж, бусад үйл ажиллагааг явуулаагүй байна.

2016 онд Монголын их хатдын түүхэн алдар гавьяа, эхчүүд эмэгтэйчүүдийн алдарыг сурталчлах зорилгоор “Монгол хатад” анхдугаар хурлыг аймаг, сумын ИТХ, ЗДТГ, Улаанбаатар хот, Хэнтий аймгийн нутгийн зөвлөл, Монголын эмэгтэйчүүдийн холбоотой хамтран зохион байгуулсан байна.

2014-2016 онд Монгол охидын зан үйл болон хөдөлмөр амралтын сургалтыг зуны улиралд 2 удаа зохион байгуулж, сумдаас 50- иад охидыг хамруулсан байна.

Хэрэгжүүлсэн үйл ажиллагааны төрлийг авч үзэхэд зорилго, зорилтыг хангалтгүй хэрэгжүүлж байна.

2.2.2. “Монгол хатдын өргөө” цогцолборын ашиглалтын өмнөх захиргаа нь үндсэн үйл ажиллагааны орлогоороо өөрөө өөрийгөө санхүүжүүлэн үр дүнтэй ажиллаж, үйл ажиллагаагаа хэвийн явуулж чадахгүй байгаагаас шалтгаалан орон нутгийн төсвөөс 2014 онд 18.2 сая төгрөг, 2015 онд 21.1 сая төгрөг, 2016 онд 14.7 сая төгрөг, 2017 онд 17.3 сая төгрөг, нийт 71.3 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгосон байна.

2.3. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй байна.

2.3.1. Тус байгууллагын санхүүгийн тайлангаас үзэхэд 2014-2017 онд үйл ажиллагаанаасаа 8.9 төгрөгийн өөрийн орлого оруулж, орон нутгийн төсвөөс 71.2 сая төгрөгийн, аймгийн Засаг даргын нөөц сангаас 5.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг авч, нийт 85.1 сая төгрөгийн зарлага гаргаж ажилласан байна. Жилдээ 1.4 - 3.6 сая төгрөгийн өөрийн орлого оруулдаг байна.

2.3.2. Мөн байгууллагын санхүүгийн тайланд “Монгол хатдын өргөө” цогцолборын барилга, байгууламж болон бусад эд хөрөнгө, тавилга хэрэгсэл, эд зүйлсийг үнэлж данс бүртгэлд тусгаагүй байна.

2.3.3. 2016 онд МУ-ын Хүний эрхийн үндэсний комисст хүсэлт явуулсны дагуу 8 сард 100 ширхэг номын фондыг нэмэгдүүлэн, 9 гэрт шинээр цагаан бүрээс, өрх худалдан авч тавьсан, гэр сургалтад зориулан 10 ширхэг сандал, 5 ширхэг ширээг нарс модоор

хийж тохижуулсан, гол өргөөний гадна хаалга, ханыг будаж, хашааны зүлэг ногоог хамгаалж цэвэрлэх зэрэг засвар үйлчилгээ тохижилтын ажлуудыг хийж гүйцэтгэн ажилласан ч хөрөнгийн чанартай эд зүйлсийг бүртгэл тайланд тусгаагүй байна.

2.3.4. Гэрээт нягтлан бодогчоор 2013-2017 онуудад санхүүгийн тайлан гаргуулсан боловч нягтлан бодох бүртгэлийг огт хөтлөөгүй байна.

Энэ нь “Монгол хатдын өргөө” цогцолборын ашиглалтын өмнөх захиргааны ажиллах журмын 3.2⁹ дэх заалтыг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

2.3.5. 2017 оны 4 сард Санхүүгийн Хяналт, дотоод аудитын албанаас тус байгууллагын 2013-2016 оны санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд шалгалт хийж, **ИХ ЭРСДЭЛТЭЙ** гэсэн дүгнэлт өгч, 7 зөвлөмж өгөгдсөнийг хэрэгжүүлээгүй байна.

Шалгалтаар санхүү, нягтлан бодох бүртгэлийн анхан шатны бүртгэл хөтлөлт хангалтгүй, авлага, өглөг ихээр үүсгэсэн, үндсэн баримтгүй, анхан шатны бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэж санхүүгийн тайланд тусгасан зэрэг 50.7 сая төгрөгийн зөрчил илэрсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7¹⁰ дэх, 18.3¹¹, 4.4¹², 8.2¹³ дэх заалтуудыг бүрэн мөрдөөгүй, дотоод хяналтыг хангалтгүй хэрэгжүүлсэнтэй холбоотой байна.

3.1. Орон нутгийн өмчийн газар нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бүтээн байгуулагдсан Монгол хатдын өргөө цогцолборын эд хөрөнгийг үнэлж данс бүртгэлд тусгах, орон нутгийн өмчид бүртгэх ажлыг зохион байгуулаагүй байна.

3.1 Хөрөнгө оруулалтаар бий болсон өмч хөрөнгийг үнэлж санхүүгийн тайлан, нягтлан бодох бүртгэлд тусгаагүй байна.

“Монгол хатдын өргөө” цогцолборын ашиглалтын өмнөх захиргаа нь санхүүгийн тайланд хөрөнгийг тусгаагүй ч гэсэн барилга байгууламж, бусад эд хөрөнгө, тавилга хэрэгслийг үнэ өртөггүйгээр, тоо ширхэгээр нь тоолж хянадаг байна.

Тус “Монгол хатдын өргөө”-ний барилгыг 445.0 сая төгрөгөөр үнэлж Баян-Адрага сумын ЗДТГ-ын санхүүгийн тайлан, үндсэн хөрөнгийн дуусаагүй барилга дансанд бүртгэсэн ч “Монгол хатдын өргөө” цогцолборын ашиглалтын өмнөх захиргааны санхүүгийн тайланд шилжүүлэн авч бүртгээгүй байна.

ОНӨГ нь дээрхи хөрөнгийг үнэлж, данс бүртгэлд тусгах ажлыг зохион байгуулаагүй, орон нутгийн өмчид бүртгээгүй нь ТБОНӨТ хуулийн 6 дугаар зүйлийн 2¹⁴, аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2013 оны 10 дугаар сарын 18-ны 88 тоот тогтоолоор баталсан “Эд

⁹ “МУ-ын Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Аудитын тухай хуулийн дагуу нягтлан бодохын болон анхан шатны, дэлгэрэнгүй бүртгэлийг хөтлөн санхүүгийн тайланг гаргаж баталгаажуулна”

¹⁰ “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”

¹¹ “Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийг хөтөлж, санхүүгийн тайланг гаргаж, тайлагнах этгээд нь мэргэжлийн, эсхүл мэргэшсэн нягтлан бодогч байна.”

¹² “Энэ хуулийн 4.1.3-т заасан стандартыг Төсвийн тухай хуулийн 4.1.34-т заасан байгууллага мөрдөнө.”

¹³ “Энэ хуулийн 4.4-т заасан байгууллага нь Төсвийн тухай хуулийн 26.3-т нийцүүлэн нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргана.”

¹⁴ “Төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгө нь төрийн болон орон нутгийн өмч байна. Төсөвт

авсан зээл, хандив, дэмжлэг, тусламжаар бий болсон хөрөнгө үүнд нэгэн адил хамаарна.”

хөрөнгийн харилцааг зохицуулах журам"-ын 3.1¹⁵, 3.2¹⁶, 3.4¹⁷ дэх заалтуудыг хэрэгжүүлээгүй байна.


Үүнд төсөл арга хэмжээг гүйцэтгэгч компаний хариуцлагагүй байдлаас шалтгаалан улсын комисс хүлээн аваагүй байсан нь нөлөөлсөн бөгөөд хөрөнгийг данс бүртгэлд үнэлж бүртгээгүйгээс өмч хөрөнгөд тавих хяналт алдагдах эрсдэлтэй байна.

3.2. Зарим хөрөнгийг зориулалтын дагуу ашиглах, хөрөнгөд засвар үйлчилгээг хийх шаардлагатай байна.


Монгол хатдын өргөө цогцолборын барилга, байгууламж, гэр, тавилга хэрэгслийг 2013 оноос хойш ашиглан үйл ажиллагаа явуулж байна.

Хөрөнгийн ашиглалт хамгаалалтын талаар газар дээр нь очиж үзэхэд дараах байдалтай байна. Үүнд:

1. Хөрөнгө ашиглалтын явцад хуучирч элэгдэн, өргөөний барилгын дээвэр, ханаас борооны ус нэвтэрч гоождог, үүдний хаалга эвдэрсэн, гадна болон дотор талын гэрэлтүүлгийн гэрлүүд шатсан, муудсан байдалтай байна.



өргөөний дотор хана



өргөөний хаалга



цогцолборын дотор хаалга

2. Монгол ээж музейн барилга, харуулын дүнзэн байшин, гэрүүдийг зориулалтын дагуу ашиглаагүй байна.


¹⁵ "Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн барилга байгууламж, их засварын ажил, худалдан авсан тоног төхөөрөмж, бусад үндсэн хөрөнгийг ашиглалтад хүлээн авсан Улсын комисс /ажлын хэсэг/-ын акт, гүйцэтгэгчээс захиалагчид хүлээлгэн өгсөн зохих баримт материалыг үндэслэн тухайн төсөл хэрэгжсэн байгууллага нь тайлан балансдаа шууд бүртгэн авна"

¹⁶ "Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон барилга байгууламжийг ашиглалтанд хүлээн авах Улсын комиссын бүрэлдэхүүнд Орон нутгийн өмчийн албаны төлөөлөл оролцох бөгөөд хүлээн авсан актыг үндэслэн тухайн барилга, объектын санхүүгийн тайланд тусгах үнэ өртгийг тооцон, эзэмшигч байгууллагыг тогтоож, санхүүгийн тайлан балансад бүртгүүлэх ажлыг хариуцан зохион байгуулах .."

¹⁷ "Орон нутгийн өмчит хуулийн этгээдэд улсын төвлөрсөн төсвөөс хөрөнгө оруулалт хийж үндсэн хөрөнгө бэлтгэсэн тохиолдолд хөрөнгийн үнэ өртөг, тоо хэмжээг тухайн хөрөнгийн санхүүжилтийг хийсэн төсвийн ерөнхийлөн болон төвлөрүүлэн захирагчийн зөвшөөрлийг авч шууд данс бүртгэлдээ тусгана."



“Монгол ээж музей”-н барилга үзмэр байхгүйгээс зориулалтын дагуу ашиглаагүй, хуучин болон зарим эд зүйлсийг хадгалах агуулахын байдалтай байна



Харуулын дүнзэн байшин нь ямарч ашиглалтгүй байна.

- 2. Хөрөнгийн хадгалалт хамгаалалтыг авч үзэхэд өргөөний хана болон дээврээс бороо ус гоожиж байгаа нь дурсгалт эд зүйлс, хөрөнгийг гэмтээж болзошгүй нөхцөл байдал үүссэн байна.

Цаашид өмч хөрөнгийг зориулалтын дагуу ашиглаж, өргөөний барилгад шаардагдах урсгал засварыг хийх, гадна дотор гэрэлтүүлэг болон тохижилтод засвар үйлчилгээ хийж, өнгө будгийг сэргээж байх шаардлагатай байна.

Аудитаар нийт 445.0 сая төгрөгийн зөрчил дутагдал илрүүлж, зөрчил дутагдлыг арилгах талаар 8 зөвлөмж хүргүүлж ажиллалаа.

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна.

- ✓ 1. Хэнтий аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2013 оны 6 сарын 13-ны өдрийн 67 дугаар тогтоолоор "Монгол хатдын өргөө" цогцолборын ашиглалтын өмнөх захиргааг байгуулсан нь Барилгын тухай хуулийн 48.3 "Гэрчилгээ олгогдоогүй, дуусаагүй барилга байгууламжид үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно." гэсэн заалтыг зөрчсөн байна.
- ✓ 2. "Монгол хатдын өргөө" цогцолборын ашиглалтын өмнөх захиргааны ажиллах журам нь хуулийн этгээдийн хариуцлагын хэлбэр ААТҮГ-т нийцээгүй, байгууллагын үйл ажиллагаа хангалтгүй байна.
- ✓ 3. Орон нутгийн өмчийн газар нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон Монгол хатдын өргөө цогцолборын барилга байгууламжийг эзэмшигч байгууллагад нь шилжүүлж, санхүүгийн тайлан балансад бүртгүүлэх ажлыг зохион байгуулаагүй байна.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аймгийн ИТХ-д

- 1. "Монгол хатдын өргөө" цогцолборын ашиглалтын өмнөх захиргаа хуулийн этгээдийг нэрийг шинэчлэн, үйл ажиллагааны дүрэм журмыг хуулийн этгээдийн хэлбэрт нийцүүлэн батлах

Аймгийн Засаг дарга-д

- 2. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд заасны дагуу "Монгол хатдын өргөө" цогцолборын захиралтай гэрээ байгуулан, үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллах

Орон нутгийн өмчийн газар-т

- 3. "Монгол хатдын өргөө" цогцолборын эд хөрөнгийг үнэлж, байгууллагын данс бүртгэлд тусгуулан, орон нутгийн өмчид орлого авах ажлыг зохион байгуулах

Санхүү, төрийн сангийн хэлтэс-т

- 4. Тус байгууллагын санхүүгийн эх үүсвэрийг аймгийн төсөвт тусган, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд чиглэл, зөвлөмж өгч ажиллах



Монгол хатдын өргөө цогцолборын ашиглалтын өмнөх захиргааны захирал-д

5. Үйл ажиллагааны зорилго, зорилтыг хангах төлөвлөгөө хөтөлбөр гарган батлуулж, тайлангаа аймгийн ИТХ-д танилцуулж байх
6. Журамд заасны дагуу үйл ажиллагааны төрлийг нэмэгдүүлж, орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх, санаачлагатай, үр дүнтэй ажиллах
7. Нягтлан бодох бүртгэл болон анхан шатны маягтыг бүрэн хөтөлж, дотоод хяналтын журам боловсруулан мөрдөж ажиллах
8. Хөрөнгийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулж эвдэрч, муудсан, элэгдэлд орсон эд хөрөнгөд засвар үйлчилгээ хийх ажлыг зохион байгуулж ажиллах

Аудитаар өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх талаар төлөвлөгөө гаргаж 2018 оны 12 дугаар сарын 01-ний дотор, авсан арга хэмжээ, хийсэн ажил, үр дүнгийн талаарх мэдээллийг 2018 оны 12 дугаар сарын 15-ны дотор албан бичгээр Төрийн аудитын азарт албан бичгээр ирүүлнэ үү.

ТАЙЛАН БИЧСЭН:

Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газрын

Ахлах аудитор		Н.Туяа
Аудитор		Ж.Болор-Эрдэнэ

2018 оны 06 дугаар сарын 20

2018.07.08

Дугаар 07

Дугаартай дараа

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
захиалгаар хийсэн нийцлийн аудитын тайлантай
танилцлаа. Санал хүсэлт байхгүй болно.



Х.ГАНБОЛД

Н. Түвшин

2018.07.08
3/111

Тайлангийн баталгаажуулалт



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2018 оны 06 дугаар сарын 30

Дугаар 21

Чингис хот

Нийцлийн аудитын тайланг батлах тухай

Монгол Улсын Ерөнхий аудиторов 2017 оны А/188 дугаар тушаалаар баталсан "Нийслэл болон аймгийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудиторт зөвшөөрөх бүрэн эрх"-ийн 2.4, Чанарын хяналтын журам-ын 5.3.4, Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газрын Удирдах Зөвлөлийн 2018 оны 06 дугаар сарын 25-ны едрийн хурлын тэмдэглэлийг үндэслэн ТУШААХ НЬ:

1. "Монгол хатдын өргөө" цогцолборын ашиглалтын өмнөх захиргааны 2014-2017 оны үйл ажиллагаанд хийсэн нийцлийн аудитын тайланг баталсугай.
2. Нийцлийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ахлах аудитор Н.Туяад даалгасугай.
3. Аудитын ажлыг үнэлж дүгнэн, үр өгөөжийг тооцож ажиллахыг аудитын менежер Д.Оюунтуяад үүрэг болгосугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭРДЭНЭБААТАР

1200129

Хэнтий аймаг дахь Төрийн Аудитын газар

"Монгол хатдын өргөө" цогцолборын ашиглалтын өмнөх захиргааны 2014-2017 оны үйл ажиллагаа -д хийсэн нийцлийн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл

2018.06.20

Байгууллагын нэр	Илэрсэн зөрчил		Эцсийн шийдвэр
	Нөхцөл байдал	мөнгөн дүн /сая.төг /	
АИТХ	Хэнтий аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2013 оны 6 сарын 13-ны өдрийн хуралдааны 67 дугаар тогтоол нь Барилгын тухай хуулийн 48.3 "Гэрчилгээ олгогдоогүй, дуусаагүй барилга байгууламжид үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно." гэсэн заалтыг зөрчсөн байна.		Зөвлөмж
АИТХ	Уг журмын 1.3-д " Орон нутгийн өмчит Монгол хатдын өргөө цогцолборын ашиглалтын өмнөх захиргаа нь Орон нутгийн өмчийн тухай хуулийн дагуу зохион байгуулагдаж, бие даасан тайлан тэнцэлтэй, банкинд харилцах данстай, өөрийн нэрийн өмнөөс эрх эдлэн, үүрэг хүлээх төсөвт байгууллагын хэлбэрээр ажиллана" гэж заасан нь улсын бүртгэлийн гэрчилгээний ААТҮГ гэсэн хуулийн этгээдийн хариуцлагын хэлбэртэй нийцэхгүй байна.		
Монгол хатдын өргөө, СТСХ	Аудитын явцад 2013-2017 оны санхүүгийн ажил гүйлгээнд нягтлан бодох бүртгэл хөтлөөгүй, гэрээт нягтлан бодогчоор санхүүгийн тайлан гаргуулдаг байна.		
Монгол хатдын өргөө	2017 оны 4 сард Санхүүгийн Хяналт, аудитын албанаас тус байгууллагын 2013-2016 оны санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд шалгалт хийж, шалгалтаар санхүү, нягтлан бодох бүртгэлийн анхан шатны бүртгэл хөтлөлт хангалтгүй, авлага, өглөг ихээр үүсгэсэн, үндсэн баримтгүй, анхан шатны бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэж санхүүгийн тайланд тусгасан зэрэг 50.7 сая төгрөгийн зөрчил илэрсэн тул ИХ ЭРСДЭЛТЭЙ гэсэн дүгнэлт өгсөн байна.		Зөвлөмж
	Шалгалтын дүнд үндэслэн 1. мэргэжлийн, орон тооны нягтлан бодогчтой болох, 2. хөрөнгийг тодорхой болгон бүртгэлд авах, 3. анхан шатны маягтыг бүрдүүлж, үйл ажиллагаандаа ашиглах, 4. хуульд заасан хугацаанд тооллого хийж хэвших, 5. байгууллагын орон тоо, үндсэн үйл ажиллагааны чиглэлийг тодорхой болгох, 6.Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, батлуулах, хэрэгжүүлэх, 7. зөвлөмжийн дагуу төлөвлөгөө гарган ажиллаж, биелэлтийг бичгээр ирүүлэх гэсэн зөвлөмжүүд өгөгдсөн нь хэрэгжээгүй байна.		
ОНӨА	Тус "Монгол хатдын өргөө" цогцолборын ашиглалтын өмнөх захиргааны санхүүгийн тайланд хөрөнгийг тусгаагүй, харин Монгол хатдын өргөөг 445.0 сая төгрөгөөр үнэлж, Баян-Адрага сумын ЗДТГ-ын үндсэн хөрөнгийн дуусаагүй барилга дансанд бүртгэсэн байна.	445	Зөвлөмж
	Мөн Монгол хатдын өргөө цогцолборын бусад эд хөрөнгө, тавилга хэрэгсэл, эд зүйлсийг үнэлж данс бүртгэлд тусгаагүй, орон нутгийн өмч хөрөнгөд орлого аваагүй байна.		
Монгол хатдын өргөө	Хөрөнгө ашиглалтын явцад хуучирч элэгдэн, өргөөний барилгын дээвэр, ханаас борооны ус нэвтэрч гоождог, үүдний хаалга эвдэрсэн, гадна болон дотор талын гэрэлтүүлгийн гэрлүүд шатсан, муудсан байдалтай байна.		Зөвлөмж
	Монгол ээж музейн барилга, харуулын дүнзэн байшин, гэрүүдийг зориулалтын дагуу ашиглаагүй байна.		
		445.0	

Зөрчлийн нэгтгэл хийсэн: Ахлах аудитор

Аудитор

Хянасан: Аудитын менежер

2317144297
СЮА0046 9074082

Н.Түяа

Ж.Болор-Эрдэнэ

Д.Оюунтүяа